



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

0605 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 101/2016003

Улаанбаатар хот

САГ - 0605 / 02 / 06 - 06 - 0605

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гео магнат ресурс ХХК-ийн 2012-2015 онд гүйцэтгэх гэрээний хугацаатай 584,785,038.00 /таван зуун наян дөрвөн сая долоон зуун наян таван мянга гучин найман/ төгрөгийн, Жи Си Эс ХХК-ийн 2014-2016 онд гүйцэтгэх гэрээний хугацаатай 539,695,683.00 /таван зуун гучин есөн сая зургаан зуун ерэн таван мянга зургаан зуун наян гурван/ төгрөгийн санхүүжилт олгосон геологийн судалгааны ажлууд өнөөг хүртэл хэрэгжиж дуусаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1. "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.6. "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1. "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Геологийн судалгааны ажлын гэрээний хэрэгжилтийг хангаагүй, хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Батцацрал/, нягтлан бодогч /Д.Даваадолгор/ нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264231

9023030583





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 402 /АО/60003

Улаанбаатар хот

СААТ - 0000 АЖ / ГД - СА - ТУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үндэсний геологийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахуун, бичиг хэрэг, нормын хувцас худалдан авах ажиллагаанд холбогдох хууль журмыг мөрдөөгүй нийт 283,235,392.00 /хоёр зуун наян гурван сая хоёр зуун гучин таван мянга гурван зуун ерэн хоёр/ төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1. "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 5 дугаар зүйлийн 5.1. "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4. "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", 24 дүгээр зүйлийн 24.4. "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль, журмыг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Батцацрал/, нягтлан бодогч /Д.Даваадолгор/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, А-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

7023030583

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-74.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 415/А0 160063

Улаанбаатар хот

САТ - 0001 / 025 / ХА - СЯ - ДАР

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Салбарын ой тэмдэглэх шаардлага хангаагүй байхад Монгол Улсад геологийн алба үүсэж хөгжсөний 85 жилийн ойн арга хэмжээнд зориулан спорт, эрдэм шинжилгээний зэрэг арга хэмжээнд нийт 119,977,600.00 /нэг зуун арван есөн сая есөн зуун далан долоон мянга зургаан зуун/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1. "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2. "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журмын 1.2. "... болон тухайн салбар байгуулагдсан өдрөөс 100 болон түүнээс дээш 50 жилийн давтамжтай тэгш ойг тэмдэглэнэ", 1.6. "Салбарын тэгш ойг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүний, ... шийдвэрээр тэмдэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг холбогдох хууль, журмын шаардлага хангаагүй үйл ажиллагаанд зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Батцацрал/, нягтлан бодогч /Д.Даваадолгор/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

ATA9693 9006109
9023030583

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
2: \Alban Shaardlaga\2025\0225 SNAG-74.Docx
ХЯЗГААРГАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 164/АД 160063

Улаанбаатар хот

СЭГТ / МОНА / ОХТ / МА - СЭТ - ОХТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй нийт 44,102,000.00 (дөчин дөрвөн сая нэг зуун хоёр мянган) төгрөгийг зарцуулж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1. "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2. "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.3. "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй ажил гүйлгээ гаргаж, санхүүгийн тайланд тусгасан зөрчлийг таслан зогсоож арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Батцацрал/, нягтлан бодогч /Д.Даваадолгор/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ

ATA9693 9006109
9023030583



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 7025 /АО 160063

Улаанбаатар хот

СААТ - 00025 / 025 / НАСАГА ТУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үндэсний геологийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1. мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.3.3. "төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар", 6.4.8. "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай тус тус нийцээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Батцацрал/, нягтлан бодогч /Д.Даваадолгор/ нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



Z:\Alban Shearddago\2025\0225 SNAG-74.Docx